

**РЭЙМОНД ГОЙССЫН НЕО-ЛЕНИНИЗМ ЛЕНИНИЗМД ХОЛБОГДОХ ТУХАЙД**

**Б.Дагзмаа**, доктор (Ph.D), профессор  
 МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш  
**Э.Эрхэс**, магистрант  
 МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим

**Товч утга:** Рэймонд Гойсс нь өөрийн улс төрийн философийг нео-ленинизм гэж тодорхойлсон байдаг. Харин В.И.Ленин нь ленинизм гэх нэр томъёоны дагуу тодорхойлолт гаргасан зүйлгүйн улмаас өнөөдрийг хүртэл цөөнгүй судлаачид тус үзэлд тодорхойлолт өгөхийг оролдсоор байна. Лениний улс төрийн онолын тухай өөр өөр судлаачдын тодорхойлолтууд дундаас Славой Жижекийн тодорхойлолт хамгийн нөлөө бүхий тодорхойлолт байсан гэж цөөнгүй судлаачид тэмдэглэдэг. Энэхүү өгүүлэлд Гойссын нео-ленинизм болон Жижекийн тодорхойлсон ленинизм нарын ялгааг тодруулах оролдлого хийсэн болно. Х онолуудаас нео-Х онолууд хэрхэн тусгаарлагдаж байдаг тухай асуудлыг кантч үзэл, феноменологи, прагматизм нарын жишээн дээр авч үзэж, гурван замыг гаргасан. Улмаар үүнийхээ тусламжтайгаар Гойссын нео-ленинизмыг ленинизмээс хэрхэн үүссэн замыг мөшигөн гаргах боломж нээгдсэн юм. Үр дүнд Р.Гойссын нео-ленинизм нь Жижекийн тодорхойлсон ленинизмтэй төстэй нэг шинж, үл ижилсэх нэг шинж буйг тодруулсан.

**Түлхүүр үг:** ленинизм, нео-ленинизм, анти-капитализм, зүүнтний үзэл

**Удиртгал**

Нео-ленинизм ямар шалтгааны улмаас бий болсон бэ? гэх асуултаас нэн түрүүнд нео-ленинизм гэдэг нь юуг эс хэлж буй тухай зарим тодруулгыг хийх зайлшгүй шаардлагатай. Нэгдүгээрт, нео-ленинизм бол ленинизм биш юм. Хоёрдугаарт, нео-ленинизм нь Лениний улс төрийн үзэлтэй категорийн хувьд ижилсэх зайлшгүй шаардлагагүй үзэл юм. Эдгээрийг тодруулахын тулд Лениний улс төрийн философи буюу онолын хувьд ленинизм хэмээгдэх улс төрийн философи ямар утга агуулга бүхий вэ? гэдэг асуултад хариулах хэрэгтэй байна. Ленин өөрөө “ленинизм” хэмээх нэр томъёог огт ашиглаагүй байдаг. Ленинизм гэх улс төр-эдийн засгийн сургаалыг бусад судлаачид Лениний үзлийг судалсны үр дүнд хийсэн бөгөөд тэдний өгсөн онолын томъёолол нь өөр хоорондоо үл ялиг ялгаатай юм.

Ленинизмын тухай орчин үеийн философичдийн зарим тайлбар

Ленинизмыг түүхийн хувьд судалж, ленинизмд тодорхойлолт өгөх гэж оролдсон гол хүн бол Бельгийн улс төрийн онолын түүхч Марсел Лийбман байв. Тэрээр “Leninism Under Lenin” бүтээлдээ ленинизм гэх нэр томъёог өргөнөөр ашигласан боловч Ленинийг “хувьсгалын онолч биш, харин хувьсгалыг гардан хийгч”<sup>1</sup> гэж үнэлсэн. Хэрэв түүний бүтээлд ленинизмын тодорхойлолт байна гэвэл ленинизм бол “(большевикийн)<sup>2</sup> либертари онол”<sup>3</sup> хэмээн бичсэнийг нь магад тодорхойлолт хэмээн зөвшөөрч болох юм.

Лийбманы дараагаар ленинизмыг тодорхойлох оролдлогыг Бузиев, Городнов нар 1987 онд хийжээ. Тэдний бичлэгийн хэв маяг өвөрмөц онцлогтой бөгөөд түүнийг нь “марксизм-ленинизм бол мөнхийн онол”<sup>4</sup> гэж томъёолсноор нь жишээлье. Тэд ленинизмд мөн адил онолын

<sup>1</sup> Liebman, Marcel (1975) “Leninism Under Lenin” translated by Brian Pearce, London: Merlin Press, p. 238

<sup>2</sup> Хаалтан дах нэмэлтийг зохиогчид нэмсэн.

<sup>3</sup> Liebman, Marcel (1975) “Leninism Under Lenin” translated by Brian Pearce, London: Merlin Press, p. 238

<sup>4</sup> Buzuev, V. & Gorodnov, V. (1987) “What is Marxism-Leninism?” Moscow: Progress Publishers, p.52.

тодорхойлолт өгч чадаагүй бөгөөд хэрэв тодорхойлолт өгсөн гэвэл “ленинизм бол... империализм, колониализмын эсрэг онол”<sup>5</sup> гэх үнэлгээг нь зөвшөөрч болох юм гэж бид үзэв.

Ленинизмд онолын хувьд тодорхойлолт өгөх оролдлогыг зарим судлаачид хийсээр байсан ч уг оролдлого ХХ зууны сүүл үед бүтэмжтэй болсон юм. Тэр нь Славой Жижеккийн тодорхойлолт байв. Жижеккийн тодорхойлолтоор ленинизм бол “анти-капиталист зүүнтний үзэл”<sup>6</sup> мөн (энэхүү өгүүлэлд дийлэнх тохиолдолд<sup>7</sup> үзэл хийгээд онол гэх ойлголтыг ижил утгатайгаар хэрэглэж буй болно) бөгөөд Каликоносын тайлбараар үүнийг бид либерал зүүнтний үзлээс ялгаатай буюу:

1. даяаршсан капитализмыг эсэргүүцсэн үзэл
2. “хариуцлагын улс төр”-ийн нэг хэлбэр<sup>8</sup> гэж ойлгох хэрэгтэй хэмээн зарим судлаачид тэмдэглэдэг.

“Жинхэнэ ленинист бол өөрийн улс төрийн онолын үр дүн хэдий таагүй байсан ч түүний хариуцлагыг үүрдэг”<sup>9</sup> гэж Каликонос ленинизмийг хариуцлагын улс төрийн онол болохын хувьд үнэлсэн байдаг. Энэ нь Ленин өөрөө ленинист болохын хувьд түүний улс төрийн онолын таамаг, үр дүн биелэхгүй бол мөн хариуцлага үүрнэ гэж дүгнэж болох юм. Ленин хэр ленинист байв? Лениний улс төрийн анализийн дагуу “Орост радикал ардчилсан хувьсгал болох нь зайлшгүй байж, мөн дэлхийн капитализм интернациональ социалист

хувьсгалд бэлэн болсон гэх дүгнэлт мөрдөгдөн гарч байсан авч тэдгээр нь аль нь ч бодит байдалтай нийцсэнгүй”<sup>10</sup> гэдгийг зарим судлаач тэмдэглэдэг. Энэ үүднээс Ленин өөрийн таамгийг бодитой бус гэдгийг харж, улс төрийн үйл ажиллагаагаа зогсоох хариуцлага түүнд байсан боловч тийм зүйл болсонгүй. Энэ нь Каликоносын үнэлгээг бүрэн хэмжээнд няцаасан хэрэг хэрхэвч биш. Ленин улс төрийн намын тухай асуудалд гойд анхаарал тавьсан нь, мөн капитализмд үүсдэг гэж түүний үзсэн санхүүгийн олигархи нь “хариуцлагын мэдрэмж”-ийг арилгадаг<sup>11</sup> гэсэн нь:

- a) хариуцлагын улс төр дэх удирдлагын хяналт, засаглалын идэвхтэй байдалтай<sup>12</sup> гарцаагүй уялддаг,
- b) мөн хариуцлагын мэдрэмжийг гээснээр эдийн засгийн амьдрал дахь ёс суртахууны агентад хариуцлага ноогдох боломжгүй болгодог гэдэг дүгнэлтийг мөрдөх тул Каликоносын үнэлгээ чухам энэхүү утгаар зөв юм.

Хэдийгээр “түүний онолын суурь болсон диалектик нь бодит амьдралын үйл явдлаас ... гарах үр дүнг нь урьдчилан тодотгодог”<sup>13</sup> гэж үзэж болох ч түүний радикал ардчилсан хувьсгал, интернациональ социализмийн бүтэлгүй таамгуудыг ленинизмээс ангид ойлгож болохгүй болж таарна. Каликоносын тодорхойлсноор (өмнө дурдсанаар) үр дүн хэдий таагүй байсан ч түүний хариуцлагыг хүлээдэг байх нь хариуцлагын улс төрийн нэг шинж. Энэ үүднээс Каликоносын өгсөн үнэлгээ ленинизмийг бүрэн тодотгож чадсангүй. Харин Жижеккийн өгсөн

<sup>5</sup> Мөн гэнд, p.51.

<sup>6</sup> Zizek, Slavoj (1999) “The Ticklish Subject” London: Verso, p. 14

<sup>7</sup> Нео-ленинизм ба ленинизм хэсгээс үзэл, онол гэх хоёр ойлголтыг тусад нь, ингэхдээ үзэл гэх ойлголтыг онол гэдэг ойлголтын дэд олонлог байдлаар хэрэглэв.

<sup>8</sup> Callinocos, Alex (2007) “Leninism in the Twenty-first Century? Lenin, Weber, and the Politics of Responsibility” In Bugden et al, p. 20

<sup>9</sup> Мөн гэнд, p. 21

<sup>10</sup> Treadgold, Donald W. (1981) “Lenin’s Political Thought: Theory and Practice in Democratic Revolution by Neil Harding” Review article, The Journal of Modern History, vol.53, p.157

<sup>11</sup> Lenin, Vladimir Ilyich (2005) “Imperialism, the Highest Stage of Capitalism: A Popular Outline” Marxist Internet Archive – Lenin Internet Archive, p. 33

<sup>12</sup> Tholen, Berry (2018) “Political Responsibility as a Virtue: Nussbaum, MacIntyre, and Ricoeur on the Fragility of Politics” Alternatives (43), p.12

<sup>13</sup> Lieberman, Marcel (1975) “Leninism Under Lenin” translated by Brian Pearce, London: Merlin Press, p. 84

“анти-капиталист зүүнтний үзэл” гэх тодорхойлолтыг энд дээрх (b)-ийн үүднээс ленинизмийн харьцангуй тохиромжтой тодорхойлолт хэмээн ойлгож, цаашид энэ утгаар тэмдэглэх болно.

### Нео-Х ба Х

Философийн түүхэнд тодорхой Х үзлийг дараа үеийн эсвэл ядаж өөр судлаачид авч хэрэглэхдээ нео-Х гэх томъёолол бүхий болгож хэрэглэсэн байдаг. Энэ тухайд Гойсс тэмдэглэсэн байдаг нь:

*ХХ зууны эхэн үеийн философич К.И.Левис нь Кантын боловсруулсан эпистемологи, метафизик санаануудыг алдаатай гэж үздэг байсан боловч өөрийгөө кантч гэж зарладаг байлаа. Мөн Лукач нэгэнтээ марксист байна гэдэг бол аргын хувьд нийгмийг түүхийн хувьд диалектикийн дагуу тогтсон “цогц(totality)” гэж үзэх явдал мөн тул зарчмын хувьд Марксын санаануудаас татгалзсан хэвээр өөрийгөө ортодокс марксист гэж үзэж болно гэж өгүүлж байсан байдаг. Үүнтэй адилаар аливаа хүн Владимир Ильич Ульяновын үзэл санаануудыг дагахгүйгээр өөрийгөө нео-ленинист хэмээж болно гэж би үзэж байгаа юм. Миний үзлээр улс төрийн философи нь улс төрийн сайтар нарийн ойлголт бүхий байя гэж буй бол, цаашилаад үйлдлийн чиг баримжаа өгөх эх үүсвэр байя гэж буй бол өнөөгийн нео-кантч байдлаасаа эргэж, “реалист” үзэлтэй болох, өөрөөр хэлвэл нео-ленинизм рүү эргэх хэрэгтэй.<sup>14</sup>*

Гойссын дурдсан жишээтэй адилаар зарим нэмэлт жишээ дурдаж, улмаар нео-Х үзэл нь эхний Х үзэлтэй ямар харилцаа

бүхий байдаг тухай ерөнхий дүгнэлт өгөх оролдлого хийе. Нийгмийн ухаан дахь нео-прагматист үзэл гэхэд “прагматизмаас ердөө тодорхой нэг хэсгээр урам зориг авсан”<sup>15</sup> байдаг. Бээртний өгүүлэлд бидний үзэж буйгаар (түүний “прагматизм ба прагматизмууд” гэх санаанд түшиглэн):

нео 1: прагматизмийн үнэний тухай тодорхойлолтыг авах,

нео 2: прагматизмийн аргазүйн тухай зарим санамжийг авах,

нео 3: эсвэл прагматизмийн шинээр дэвшүүлсэн асуудлыг авч ашиглах зэргээр нийгмийн ухаанд төрөл бүрээр хэрэглэгдэж болно гэсэн гурван утга илэрч байв.

1870-аад оноос “зарим феноменологичид жинхэнэ Кант руу эргэх оролдлого хийж, улмаар Кантын өөрийн үл зөвшөөрөх асуудлууд руу орсон нео-кантчидтай мэтгэлцэж байснаараа тэдгээр феноменологичид анти-нео-кантч байв. ...Харин Гуссерль Brentano-гоос урам зориг авсны хувьд ... нео-кантчдыг хамгаалж байв.”<sup>16</sup> гэсэн зэргээс үзвэл нео-Х үзэл нь тухайн Х үзэлтэй “урам зориг”-ийн харилцаатай байдаг гэх дүгнэлтийг хийж болно. Энэхүү “урам зоригийн харилцаа” хэмээх томъёолол Гойссын дурдсан нео-кантч Левис, нео-марксист Лукач нарын хувьд мөн таарч буй буюу Лукачийн хувьд зөвхөн аргазүйн хувьд (тэр дундаа ялангуяа диалектик) Марксаас урам зориг авсан бол Левисийн хувьд Кантаас “априорийн тухай санааг авч, өөрийн философид аргазүйн хувьд ашигласан”<sup>17</sup> зэрэгт тус харилцаа илэрч байна. Лукачийн хувьд диалектик түүний шинэ философийн чухал нэг урам зориг байсан бол Левисийн хувьд априори нь шинэ философио бүтээх чухал нэг урам зориг байж. Бээртний “прагматизм ба

<sup>14</sup> Geuss, Raymond (2008) “Philosophy and Real Politics” Princeton University Press, pp. 98-99

<sup>15</sup> Baert, Patrick (2011) “Neo-Pragmatism and Phenomenology” European Journal of Pragmatism and American Philosophy (Online)

<sup>16</sup> Luft, Sebastian (2018) “Kant, Neo-Kantianism, and Phenomenology” Oxford Handbook of the History of Phenomenology (07/18), Oxford University Press, pp. 2-6

<sup>17</sup> Gava (2018) “C.I.Lewis, Kant, and the reflective method of philosophy” British Journal for the History of Philosophy, pp.1-21

прагматизмууд”-аас гарган авсан үнэлгээн дэх “прагматизм” гэх тодорхой үзлийг ямар нэг Х үзлээр орлуулж, улмаар тус үнэлгээний дагуу тодруулж хэлвэл Лукач нео-2 замаар, Левис нео-3 замаар нео-Х онолоо боловсруулсан болж таарав. Нео-Х ба Х-ийн хоорондох “урам зоригийн харилцаа”-г Х бол прагматизм, кантианизм, марксизм зэрэг байх үед илэрч байна. Эдгээрт үндэслэн бид индуктив байдлаар нео-Х үзэл нь Х-тэй урам зоригийн харилцаанд оршдог, ингэхдээ дээр дурдсан гурван замын аль нэгээр дамждаг гэсэн дүгнэлтийг өгч буй юм.

### Нео-ленинизм ба ленинизм

Гойсс нь улс төрийн философийн хүрээнд шинэ үзэл боловсруулж, түүнийгээ “нео-ленинист”<sup>18</sup> хэмээн томъёолдог. Уг шалтгаанаар энэхүү өгүүлэлд “түүний улс төрийн философи” ба “нео-ленинизм” хоёрыг хойшид ижил утгатайгаар хэрэглэнэ. Тэрбээр нео-ленинизмыг гурван багц асуудлын хүрээнд авч үзэх хэрэгтэй гээд М.Вебер, В.И.Ленин, Ф.Ницше нарыг дэвшүүлж өөрөө судлан өгүүлжээ.

Гойсс нь “Философи ба Жинхэнэ улс төр” бүтээлдээ Вебер, Ницше, Ленин нарын асуудлыг нео-ленинист улс төрийн философийн үндэс байна гэж үзсэнийг энд үзүүлбэл:

Вебер	Ёсчлон батлал
Ницше	Эрхэмлэх зүйл, илүүд үзэх зүйл, оновчтой цаг
Ленин	Хэн, хэнийг

Тэрээр Лениний дэвшүүлсэн “кто, кого (who whom)” гэх асуудлыг “улс төрийн амьдралд тогтмол эргэлдэх асуудлыг (Ленин) томъёолж илэрхийлсэн”<sup>19</sup> гэж үнэлдэг. Ленинизмын дэвшүүлсэн тодорхой асуудлыг авсны тул, Х үзлээс нео-Х үзэл рүү шилжих гурван замын хувьд Гойсс нео-3 замын дагуу шилжилт

хийсэн байна. Мөн тэрээр “Лениний улс төрийн онол дахь бусад гол үзлийг баримтлалгүйгээр нео-ленинист байж болно”<sup>20</sup> хэмээн өөрийн байр суурийг илтгэсэн явдал нь уг замаар хийсэн шилжилтэд зөвтгөл болох юм. Энд эхэнд дурдсан хоёр тодруулгыг өмнө дурдсан мэдээллүүдээр батагган өгүүлэхэд:

1. нео-ленинизм бол ленинизм биш (нео-Х ба Х-ийн харилцааны учир)
2. нео-ленинизм нь Лениний улс төрийн үзэлтэй категорин хувьд ижилсэх зайлиггүй шаардлагатай биш (учир нь зөвхөн тодорхой нэг асуудлын хүрээнд ижилсэж буй) юм.

Бид ленинизмыг Жижекийн тодорхойлсноор “анти-капиталист зүүнтний үзэл” гэдэг утгаар ойлгон хэрэглэх тухай, ийн хэрэглэх нь зөв болохыг ленинизмд өгсөн бусад тодорхойлолтуудад үнэлгээ өгч ленинизмын тодорхойлолтын тухай байр сууриа илэрхийлсэн. Ленинизмын тодорхойлолтод хоёр элемент буй нь: 1. анти-капиталист; 2. зүүнтний үзэлтэй байх.

Гойссын нео-ленинизм анти-капиталист уу? Морган энэ тухайд анхаарал нэлээд хандуулсан ба Гойсс өөрийн бүтээлүүдийн дундаас капитализмтай хамгийн ойр байж чадах сэдэв бүхий бүтээл болох “Public Goods, Private Goods”-ийг 2001 онд бичсэний хойно буюу 2005 онд Морган түүний улс төрийн онолыг судалсан байдаг. Ингэхдээ Морган нь Гойссыг нео-ленинист хэмээх томъёоллын дагуу авч үзсэнгүй, харин реалист гэх томъёоллын дагуу авч үзсэн юм. Хэрэв тэрээр нео-ленинист гэдэг томъёоллын дагуу авч үзсэн бол “капитализмын тухай Гойсс нарийвчлан авч үздэггүй”<sup>21</sup> гэж биш, магад анти-капиталист гэж үнэлэх бололцоо байсныг үгүйсгэхгүй. Хожим

<sup>18</sup> Geuss, Raymond (2008) “Philosophy and Real Politics” Princeton University Press, p. 99

<sup>19</sup> Мөн тэнд, p. 23

<sup>20</sup> Мөн тэнд, p. 99

<sup>21</sup> Morgan, Glyn (2005) “The Realism of Raymond Geuss” Government and Opposition, Vol.40, p. 119

Гойсс капитализмын тухай өөрийн үзлийг илтгэхдээ хэдий хангалттай нарийвчлал бүхий биш боловч, капитализмыг дэмждэг эсэх тухай байр сууриа илэрхийлэв. Тэрээр Т.Адорногийн капитализмыг эсэргүүцэж байсан үзлийг баримталсны үүднээс "...хүний өөрийгөө хүндлэх байдлын хамгийн бага илэрхийлэл бол капитализмын сүүл үед <<бүрэн тухтай>> мэдрэмжийг авахгүй байх явдал"<sup>22</sup> хэмээж, мөн түүний дээр хүйтэн дайны үеийн барууны нийгмүүд эдийн засгийн хувьд үр ашигтай байсан боловч "ажил, амьдрал хоёрыг салгаж чадаагүй"<sup>23</sup> гэж үзэн, тус (түүний үзсэнээр) дутагдал нь Зөвлөлтийн нийгэм "эдийн засгийн үр ашиггүй"<sup>24</sup> гэх барууны нийгмийн зүгээс тус нийгэмд оноож байсан, мөн зарим утгаар өдгөө ч оноодог дээрх дутагдалтай харьцуулахад төдийлөн ялгаагүй хэмээн үнэлдэг. Улмаар мөн тэнд тэрээр эдийн засгийн ашиггүй байх явдал нь шүүмжлэлийн үндэс болж чадахгүй гэсэн санааг өгүүлсэн байдаг. Энд анхаарууштай зүйл бий юм. Марксизмд хийгээд ленинизмд бид хүнийг нэгж агент болохынх нь хувьд "өөрийгөө хүндлэх байдал бүхий" тухай асуудлыг авч үздэггүй. Харин Адорногийн хувьд марксизм ба ленинизмээс уг асуудлаар ялгарч, Гойсс түүнийг нь хүлээн авсан байдаг явдлыг онцлон анхаарах хэрэгтэй.

Тэрээр капитализмыг шүүмжлэх асуудлыг "ёс суртахууны хувьд"<sup>25</sup> өгүүлэв. Этицизмийг улс төрийн онолын төвд байхыг эсэргүүцдэг<sup>26</sup> философичийн хувьд ёс суртахууны асуудлыг хөндөх явдал нь ховор авч, "зүй ёс"-ыг абстракционизмд түшиж хийхийг буруу гэж үзсэн ч, огт

хийхгүй байхыг санал болгодоггүй тэрээр "өндөр хөгжсөн капиталист нийгмүүд Роулсын зүй ёсыг ... чухал гэж үзэх явдлыг хэрхэн дэмжих нь нэн тодорхой бус байдаг"<sup>27</sup> гэж бичсэн юм. Иймд бид түүний хүсэж буй капитализмд хийх орлуулга нь ямартай ч "сайн", мөн Т.Адорногийн үзлийг дагасны хувьд "хүн өөрөө өөрийгөө хүндлэх боломжтой", удаад нь "ажил, амьдрал нь тусдаа"<sup>28</sup> нийгмийг бий болгох зорилготой гэж дүгнэж болж байна. Энд цухас сануулахад Т.Адорно капитализмыг философийн үүднээс эсэргүүцсэн нэг шалтгаан нь түүний гуманист хандлага байдаг бөгөөд тэрээр капиталист нийгэмд хүн бол хувь хүн биш, зөвхөн хэрэглэгч бөгөөд тус байдлаас илүү гарч амьдрах бололцоо түүнд байдаггүй хэмээн үзэж байсан явдал юм. Гойсс Адорногийн гуманист хандлагыг баримтлан дурдсан орлуулгыг дэвшүүлж буй. Харин орлуулгынхаа<sup>29</sup> талаар дэлгэрэнгүй дурдсан зүйлгүй тул бид Морганы нэгэн адилаар түүний эдийн засгийн талаарх үзлийг нарийвчлан тодорхойлох боломжгүй байна. Гойссыг улс төрийн онолын реалист болохынх нь хувьд судалсан Морган "капитализмын мөн чанарын тухай өгүүлсэн зүйлгүй байдаг нь Гойссын бүтээлүүд дэх дутагдал байна"<sup>30</sup> хэмээсэн. Морганаас ялгаатай нь бид Гойссыг а) нео-ленинист болохынх нь хувьд, мөн б) Адорногийн гуманист хандлагыг баримтлагч болохынх нь хувьд авч үзсэн явдал юм. Харин Гойсс нь анти-капиталист мөн гэсэн дүгнэлтийн үндэслэлүүд энэ цаг үед түүний шинэ бүтээлүүдийн ачаар ил болсон аж. Энэ нь Морганы хариулт өгч чадахгүй байсан тэр асуултын (Гойсс

<sup>22</sup> Geuss, Raymond (2014) "A World without Why" Princeton University Press, p. 185

<sup>23</sup> Мөн гэнд, p. 55

<sup>24</sup> Мөн гэнд, p. 56

<sup>25</sup> Мөн гэнд, p. 56

<sup>26</sup> Hall, Edward & Sleat, Matt (2017) "Ethics, morality, and the case for realist political theory" Critical Review of International Social and Political Philosophy, p.277

<sup>27</sup> Geuss, Raymond (2008) "Philosophy and Real Politics" Princeton University Press, p. 91

<sup>28</sup> Энд өгүүлсэн "тусдаа (alienated)" гэх ойлголтыг дийлэнхи Монгол судлаачид (зонхилон социологичид) "хүнийссэн" хэмээн хэрэглэдэг. Ажил, амьдрал зэрэг ойлголтууд нэг нэгнээсээ хүнийсвэл, судлаачид бид тус ойлголтуудыг хүншүүлсэн болох билээ. Тийн хүншүүлэх үйлдэл хийхгүйн тулд өөр үгээр хэрэглэсэн нь "тусдаа" болно.

<sup>29</sup> Дурдан буй энэхүү "орлуулга" нь логик, математикт хэрэглэгддэг "эквивалент шинж бүхий өөр хувьсагчаар орлуулах" гэсэн утгагүй болохыг тэмдэглэе. Энэхүү "орлуулга" гэх ойлголтыг Р.Гойсс өөрийн бүтээлд тус утгаар бус, харин "шинэ утга оноолт бүхий ойлголтоор орлуулан өөрчлөх" гэх утгаар хэрэглэдэг юм.

<sup>30</sup> Morgan, Glyn (2005) "The Realism of Raymond Geuss" Government and Opposition, Vol.40, p. 119

капитализмаас “бүрэн” татгалздаг эсэх) хариу нь өдгөө ил болсон гэсэн үг. Түүний зүгээс капитализмд өгч буй шүүмжийг хэлбэрчилвэл:

Нөхцөл 1: (Аль нэг хэлбэрийн) капитализм эдийн засгийн үр ашгийг урьтал болгосноор ажил, амьдралыг салгадаггүй.

Нөхцөл 2: Ажил, амьдралыг салгахгүй байх нь хүнийг өөрөө өөрийгөө хүндлэх байдалд халддаг.

Нөхцөл 3: (Ямарваа) хүн өөрөө өөрийгөө хүндэлж чаддаг явдал нь сайн нийгмийн шинж мөн.

Дүгнэлт: Иймд капитализм муу.

Энэхүү дүгнэлтийг капитализмын ёс суртахууны үнэлэмжид хийж буй тул анзааргагүй хандаж “хар эсвэл цагаан” гэх формал бус логик алдаа хийж буй хэрэг биш юм. Харин сайн ба муу гэх хоёр үнэлэмж нь энэхүү нөхцөлд байх бүх боломж юм гэсэн бодомжид тулгуурлан хийсэн болно. Тус шалтгаанд үндэслэн хүн өөрөө өөрийгөө хүндлэх боломжийг хангадаг нийгэм нь сайн нийгэм бол, үүний эсрэг нийгэм нь муу нийгэм гэсэн дүгнэлтийг хийв.

Нео-ленинизм нь ленинизмтэй адил анти-капиталист бол, мөн ленинизмын адил зүүнтний үзлийг баримталдаг уу? Гойсс энэ тухайд өөр саналтай байв. Тэрээр Гегель, Маркс зэргээс голлон шалтгаалж “цөөнгүй зүүнтний үзэлтний баримталдаг амьдралын утга учраа хүн өөрөө бүтээж болно”<sup>31</sup> буюу хувь хүн нийгмээс бүрэн ангид байдлаар (тухайн нийгмийн эдийн засаг, улс төрийн байдлаас үл шалтгаалан) өөрийн амьдралд утга оноох боломжтой хэмээдэг явдлыг хатуу эсэргүүцдэг.

Нөгөө талаар “амьдралын утга учрыг бид өөрсдөө бүтээдэг биш, харин бидэнд тулгагдаж ирдэг зүйл гэж үзэх явдалд ямар ч баруунтны үзлийн шинж байхгүй”<sup>32</sup> хэмээснээр а) амьдралын утга учрыг бидэнд тулгагдан ирдэг зүйл гэж үздэг, б) өөрөө баруунтны үзлийг баримталдаггүй гэсэн хоёр мэдээг бидэнд өгч байна. Өмнө ашигласан “хар ба цагаан” формал бус алдаанаас булталгүйгээр түүнийг зүүнтний үзэлтэн гэж дүгнэх боломж энд байна уу? Зүүнтний үзэлтэн хэмээн үнэлэх гэтэл амьдралын утга учрын тухай үздэг түүний үзэл зүүнтний үзэлтэй радикал байдлаар зөрчилдөж буй асуудлыг хэрхэн даван туулах вэ? Энэхүү хоёр асуултад хариулах боломж бидэнд байна. Ингэхдээ сүүлийн асуултад нь эхэлж хариулах хэрэгтэй бололтой. Чухам тэгж байж логик дараалал бүхий хариулт үүсэх юм. Гойсс “улс төрийг баруунтны ба зүүнтний хэмээн хуваах сэтгэлгээ нь (большевикийн)<sup>33</sup> хувьсгалаас эхтэй”<sup>34</sup>, мөн “энэхүү (баруунтны ба зүүнтний гэх)<sup>35</sup> байр сууринаас цааш явах эсэх нь надад тодорхойгүй байна”<sup>36</sup> хэмээдэг юм. Сүүлийн дурдсан эшлэлд илрэх реторик нь бидний дээр дурдсан зүй ёс ба капитализмын эшлэл дэх реториктой хэлбэрийн хувьд адил байна. Түүний “А нь В болох эсэх нь тодорхойгүй байна” гэх реторик нь хэрэг дээрээ “А нь В болох хэрэгтэй” гэдгийг илэрхийлдэг аж. Иймд сүүлийн асуултад өгөх хариулт нь тэрээр баруунтны болон зүүнтний үзлийн алинд ч өөрийгөө хамаатуулдаггүй гэх явдал мөн. Үүнээс уламжлан эхний асуултын хариу мөрдөгдөж гарах буюу баруунтны ба зүүнтний гэх эсрэгцэл бүхий хоёр л боломж энд байхгүй байна. Чухам тийм учир “хар ба цагаан” формал бус алдаанаас энэ тохиолдолд сэрэмжлэх нь зөв юм гэсэн дүгнэлт урган гарах юм.

<sup>31</sup> Geuss, Raymond (2014) “A World without Why” Princeton University Press, p. 102

<sup>32</sup> Мөн гэнд, р. 104

<sup>33</sup> Хаалган дахь нэмэлтийг зохиогчид нэмсэн.

<sup>34</sup> Geuss, Raymond (2014) “A World without Why” Princeton University Press, p. 103

<sup>35</sup> Хаалган дахь нэмэлтийг зохиогчид нэмсэн.

<sup>36</sup> Geuss, Raymond (2014) “A World without Why” Princeton University Press, p. 111

Гойссын нео-ленинизм нь ленинизмтэй адил анти-капиталист боловч, зүүнтний үзлийг баримталдаггүйгээрээ ялгаатай юм байна. Энэ нь категорийн хувьд ижилсэх зайлшгүй шаардлага байхгүй гэсэн нөхцөлийг мөн хангаж байгаа болно.

### Ном зүй

1. Baert, Patrick (2011) “Neo-Pragmatism and Phenomenology” *European Journal of Pragmatism and American Philosophy* (Online), III-2
2. Buzuev, V. & Gorodnov, V. (1987) “What is Marxism-Leninism?” Moscow: Progress Publishers
3. Callinocos, Alex (2007) “Leninism in the Twenty-first Century? Lenin, Weber, and the Politics of Responsibility” In Bugden et al, pp.18-41
4. Gava (2018) “C.I.Lewis, Kant, and the reflective method of philosophy” *British Journal for the History of Philosophy*, pp.1-21
5. Geuss, Raymond (2008) “Philosophy and Real Politics” Princeton University Press
6. Geuss, Raymond (2014) “A World without Why” Princeton University Press
7. Hall, Edward & Sleat, Matt (2017) “Ethics, morality, and the case for realist political theory” *Critical Review of International Social and Political Philosophy*, pp.276-290
8. Lenin, Vladimir Ilyich (2005) “Imperialism, the Highest Stage of Capitalism: A Popular Outline” Marxist Internet Archive – Lenin Internet Archive
9. Liebman, Marcel (1975) “Leninism Under Lenin” translated by Brian Pearce, London: Merlin Press
10. Luft, Sebastian (2018) “Kant, Neo-Kantianism, and Phenomenology” *Oxford Handbook of the History of Phenomenology* (07/18), Oxford University Press
11. Morgan, Glyn (2005) “The Realism of Raymond Geuss” *Government and Opposition*, Vol.40, pp.110-120
12. Tholen, Berry (2018) “Political Responsibility as a Virtue: Nussbaum, MacIntyre, and Ricoeur on the Fragility of Politics” *Alternatives* (43), pp.22-34
13. Treadgold, Donald W. (1981) “Lenin’s Political Thought: Theory and Practice in Democratic Revolution by Neil Harding” Review article, *The Journal of Modern History*, vol.53, pp.157-159
14. Zizek, Slavoj (1999) “The Ticklish Subject” London: Verso

***Abstract:** Raymond Geuss describes his political philosophy under the term ‘neo-Leninism.’ Lenin had not defined what Leninism is, and in fact there has been numerous definitions given to it by different authors up to this day. Among varying definitions upon the political theory of Vladimir Lenin, it is believed by many that the definition of Slavoj Zizek is, so far, the foremost. In this article, the author tried of outlining a difference between the neo-Leninism of Geuss, and the Leninism defined by Zizek. In doing so, the author tried outlining three characteristics of how neo-X theories are separated from the former X theories: on the basis of Kantianism, phenomenology, and pragmatism, comparing with their neo-X schools. Neo-Leninism of Geuss seemed to be in relation with Leninism through one of three characteristics outlined. Having remarked such characteristics, the possibility of tracing neo-Leninism of Geuss back to Leninism is seen to emerge. As a result, neo-Leninism seemed to have one similarity, and one difference with Leninism as defined by Zizek.*